



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

180

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 87 НАГ-БНАТАГ-1018/02 НА Номгон

Г

Санал хүргүүлэх тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “2016, 2017 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх”-т хийсэн нийцлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг. Хавсралтад заасан 2016 оны 6, 2017 оны 7-н худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг зөв үнэлж, хянаагүй

Хоёр. 2017 онд аймгийн Шүүхийн Тамгын газар, Цагдаагийн газар, аймгийн ЗДТГ-т орон сууц худалдан авсны дараа тендерийг нөхөн зохион байгуулсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх “...тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн үзүүлэлтээр тодорхойлох”, 11.1.3 дэх “...барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайллан заасан шаардлага, нөхцөл тавихгүй”, 27 дугаар зүйлийн 27.1 дэх “Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараахь шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ...”, 28.1 дэх “Нэг үе шаттай тендер шалгаруулалтын үед энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хянаж, шаардлагад нийцсэн гэж үзсэн бүх тендерт үнэлгээ хийнэ”, 29.2 дахь “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна”, 30.4.1 дэх “Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад

161

шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах“, Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан журмын 4.2 дах “Үнэлгээний хорооны хуралдаан үнэлгээний хорооны дарга, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга болон бусад гишүүдийн дийлэнх олонх буюу 75 хувиас дээш ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д “... гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Нэг. Дээрх үнэлгээний хороодод ажиллаж, зөрчил гаргасан албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ авч, холбогдох баримтыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.13-т заасны дагуу ажлын 10 хоногийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Хоёр. Албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу шийдвэрлүүлэх болно.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

АУДИТОР

П.МӨНХ-ЭРДЭНЭ

АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ

ЗӨВШӨӨРСӨН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

Г.БАТЖАРГАЛ

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын
газрын 2018 оны 06 дугаар сарын 29-ний
өдрийн 87 тоот албан шаардлагын хавсралт

ДД	Төсөл, арга хэмжээний нэр	Илэрсэн зөрчлийн утга
2016 он		
1	Баянхонгор сумын 2-р цэцэрлэгт хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх	Уг тендерийн хүнсний ногоо жимс жимсгэний багцад "Хөшөөт арвижих далай" ХХК 6506,8 мянган төгрөг буюу хамгийн бага үнийн санал ирүүлсэн байтал 7209,8 мянган төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Далай ээж Баянхонгор" ХХК-ыг шалгаруулж ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зөрчсөн байна.
2	Баянхонгор сумын 6-р цэцэрлэгт хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх	Хүнсний ногоо нийлүүлэх тендерт "Хөшөөт арвижих" ХХК ерөнхий шаардлага хангаагүй байхад үнэлж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн гэж шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зөрчсөн байна.
3	Гэрэлтуүлгийн засварын автокран худалдан авах	Техникийн тодорхойлолтод "2014, 2015 онд ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх" гэж заасан байхад "Оточ Царам дринллинг" ХХК-ийг ижил төстэй ажил гүйцэтгээгүй байхад шалгаруулсан нь хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зөрчсөн байна.
4	Цагдаагийн газрын албан хэрэгцээнд шаардлагатай суудлын авто машин авах	Тендерт материал ирээгүй байхад үнэлгээний хорооны олонхийн саналаар шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1 дэх хэсгийг зөрчсөн байна.
5	Өвс, тэжээл нийлүүлэх /Баянхонгор/	Үнэлгээний хороо бүх тендерээс татгалзсан атлаа захиалгчид шууд гэрээ байгуулах зөвлөмж өгсөн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1 дэх хэсгийг зөрчсөн байна.
6	Баянхонгор сумын 1-р цэцэрлэгт хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх	Тендерийн үнэлгээний хороо 7 гишүүнээс тендер шалгаруулах хуралд 71,4% буюу 5 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдсан байхад хурлын тэмдэглэлд 80%-ийн ирцтэйгээр тэмдэглэж, шалгаруулалтыг хийсн нь Сангийн сайдын 2014 оны 212 тоот тушаалаар батлагдсан журмын 4.2 дах заалтыг хэрэгжүүлээгүй байна.
2017 он		
7	АЗДТГ-ын цэцэрлэгт байгуулах	Ажилтан Б.Батзориг, Ж.Бадамцэгийн нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар байхгүй, Налайх дүүргийн ажилтан Ц.Мөнхдоржийн нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг ирүүлсэн, гэрээний хугацаа дууссан автомашин түрээслэх гэрээг ирүүлсэн гүйцэтгэгчийг шалгаруулж ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зөрчсөн байна.
8	"Чандмань Баянхонгор ХХК"-ийн цэцэрлэгт байгуулах	Тендерийн үнэлгээний хороо 2017.07.24-ны өдөр хуралдаж, Засаг даргад "Хаш голоо" ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн, аймгийн Засаг даргаас тус ААН-д 2017.08.02-ны өдөр мэдэгдэл хүргүүлсэн байхад гэрээ тендер шалгаруулалт явагдахаас өмнө буюу 2017.07.20-ны өдөр гэрээ байгуулж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 29 дугаар зүйлийн 29.2 дах заалтыг зөрчсөн байна.
9	Баянхонгор сумд баригдах "Хуримын ордон"-ны барилгын ажлын зураг төсөв боловсруулах /ТЭЗҮ/	"Урбан девелопмент консалтинг групп" ХХК нь 2015 онд байгуулагдсан, 2016 онд тусгай зөвшөөрлөө авсан, туршлага дээр 2011 оноос ажил гүйцэтгэснээр мэдээлэл ирүүлсэн, бүх банкны тодорхойлолт ирүүлээгүй байхад гүйцэтгэгчийг шалгаруулж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зөрчсөн байна.

10	Спорт цогцолбор барих /Баянхонгор, Бөмбөгөр сум/	О.Ганболд, Б.Чинзориг,Ө.Төгсгэрэл нарын цалин НД 8 маягаар мэдээлэгдээгүй, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар ирүүлээгүй, 2014-2016 оны хооронд "Жигүүр бодг" ХХК, Ж.Менжаргал, Ц.Ганзориг, Ч.Цэрэнлхагва настай маргаан үүсч эвлэрлийн гэрээ байгуулсан тухай Шүүхийн Тамгын газрын тодорхойлолттой гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зерчсөн байна.
11	Баянхонгор аймгийн "Байгалийн түүхийн музей"-н барилгын дээвэр, халаалтын засварын ажил	Үнийн хөнгөлөлт тооцсон анхны тендериийг ТБОНӨХБАУХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтын дагуу зөв хянаж үнэлээгүйгээс тендер дахин зарлаж, уг тендерт үнийн хөнгөлөлт байхгүйгээс төсвийг 8.2 сая төгрөгөөр хэмнэх боломжийг алдсан байна.
12	Аймгийн БСУГ-т сургалтын хэрэглэгдэхүүн, тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх	ТОӨЗ 1.1-д заасан 2015, 2016 оны санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл, борлуулалтын хэмжээ, удирдах ажилтны танилцуулга зэрэг шаардлагуудыг хангагүй байхад гүйцэтгэгчээр "Баялаг Ундарга" ХХК-аар шалгаруулж, ТБОНӨХБАУХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг зерчсөн байна.
13	12,17-р байрнуудын гадна пасад, орц, бохирын шугамын засвар	12,17-р байрнуудын гадна пасад, орц, бохирын шугамын засварын ажлын тендериийн баримт бичгийг шалгахад уг ажлыг гүйцэтгэгчээр шалгарсан "Хүрэн жинсийн овоо" ХХК нь ТОӨЗ-д заасны дагуу инженер техникийн ажилтнуудын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар ирүүлээгүй, мөн ТОӨЗ-ийн 5.3 в-д заасан ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэж, гэрээ болон хүлээлгэн өгсөн комиссын актыг хавсаргана гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй байгаа нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 27, 28 дугаар зүйлийн 27.1, 28.1 дэх заалтуудыг зерчсөн байна.
14	2017 онд аймгийн Шүүхийн Тамгын газар, Цагдаагийн газар, аймгийн ЗДТГ-т орон сууц худалдан авсны дараа тендериийг нөхөн зохион байгуулж хуулийг зерчсөн байна.	Худалдан авсан орон сууцанд тохирсон техникийн тодорхойлолтыг бэлтгэсэн нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3 дахь хэсгийг зерчсөн байна.

--- оОо ---